

**Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа, албадлагын арга
ХЭМЖЭЭ**

ЭРХ ХАСАХ ЯЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

THE CONCEPT OF DEPRIVATION OF RIGHTS



Э.Батбаяр

*ДХИС-ийн Сургалт, судалгааны 403 дугаар анги-
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн профессор,
доктор (Ph.D), дэд профессор, хурандаа*

Товч утга: Энэхүү өгүүллээрээ эрх хасах ялын үзэл баримтлалын талаар манай эрдэмтэн судлаачдын бичсэн мөн олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжид хэрхэн зохицуулсан талаар харьцуулан судалж, тодорхойлохыг зорилоо.

Түлхүүр үгс: Үзэл баримтлал, ял, хорихоос өөр төрлийн ял, эрх хасах ял

Abstract: This article aims to compare and analyze the concept of deprivation of liberty as written by our scholars and how it is regulated in international treaties and national laws.

Key words: Concept, punishment, alternative penalty, non-custodial sentence, disqualification sentence

ҮНДСЭН ХЭСЭГ

Үзэл баримтлал /концепци/ гэдэг нь аливаа үзэгдэл юмс, үйл явцыг тодорхойлж ойлгох, боловсруулж шийдвэрлэхдээ удирдлага болгосон үзэл бодлын тогтолцоо ... зорьж баримталсан нэгдмэл, тодорхойлогч гол үзэл сэтгэмжийг хэлэх (Чимид, 2006, хууд. 36) агаад эрүүгийн ял шийтгэлийн тухайд ч зайлшгүй яригдах ёстой суурь ухагдахуун юм.

Үзэл баримтлал гэж юуг ойлгох, ямар утга агуулгыг багтаах, ялын хувьд үзэл баримтлалыг хэрхэн зохиох, тавигдах шаардлага, үндэслэл, ач холбогдол, өмнөх ба одоогийн Эрүүгийн хуулийн гол үзэл баримтлал, тогтсон чиглэл, хандлагын талаар болон онол, арга зүйн асуудлыг “торгох

ялын үзэл баримтлал” гэсэн сэдэвт дэлгэрэнгүй авч үзсэн тул түүнээс тодруулж үзэхийг зөвлөж байна.

Ялын бодлогын хүрээнд тухайн төрлийн ялыг шинээр бий болгох, эсхүл хасах буюу татгалзах нь Үндсэн хуулийн үзэл санаа, эрүүгийн ялын сургаалын хөгжил, дэлхий дахины чиг хандлага, жишиг, хууль тогтоомжийн хэрэглээ, практик, үүх түүх, улс орны онцлог зэрэгтэй холбоотой. Тухайлбал:

Эрүүгийн хуулийн тусгай ангид тодорхой албан тушаал эрхлэх буюу үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг үндсэн ялын чанартай хэрэглэх заалт байхгүйгээс эрх хасах ялыг бараг хэрэглэхгүй болжээ. (Монгол Улсын Дээд шүүх, 2025, хууд. 1)

Эрүүгийн хуулиас “цэргийн болон бусад цол, түүнчлэн одон медаль, хүндэт алдар цол хасах” зэрэг ялыг хасах болсон шалтгаан нь эдгээр ялын зарим нь Үндсэн хуулийн үзэл баримтлал, утга агуулгатай харшилсан, шүүхийн практикт бараг хэрэглэгдэхээ больсон, зарим хууль тогтоомжтой зөрчилдсөн зэрэгтэй холбоотой. **Жишээлбэл:** улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон медалиар шагнах, тэдгээрийг хасах асуудал Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамаарна. (Нарангэрэл, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /Ерөнхий анги/, 1996, хууд. 282)

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “... Хүн бүр улсдаа төрийн алба хаших тэгш эрхтэй”, “... Ардчилсан нийгмийн ёс суртахууны шударга шаардлага, нийгмийн хэв журам, ерөнхий сайн сайхан байдлыг хангах үүднээс хуульчлан тогтоосноос өөр хязгаарлалтад өртөгдөх ёсгүй” гэж заасан /үз. 21 /2/, 29 дүгээр зүйл/ байдаг.

Проф. Г.Совд 1995 онд “Монгол Улсын Эрүүгийн цаазыг /хууль/ өөрчлөх үзэл баримтлал”-ыг боловсруулж, улмаар “Монгол Улсын Эрүүгийн цааз”-ын онолын загварыг зохиож байжээ.

Тэрээр “... гэмт хэрэг түүнд хүлээлгэх хариуцлагын тухай асуудалд анги, нам, хөрөнгө чинээ, үзэл бодлын ялгаатай байр сууринаас ханддаг социалист үзэл баримтлалаас бүрэн татгалзах учиртай” гэж (Совд, Монгол Улсын Эрүүгийн цааз /онолын загвар/, 1995, хуудсд. 34, 36) үзээд “... Эрүүгийн цааз /онолын загвар/ -ынхаа;

- 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “ж”-д “цэргийн болон тусгай алдар цол хасах, одон медаль хураах” гэсэн ялын төрөл байхаар;

- 24 дүгээр зүйлд “... гэм буруутай этгээд гэмт хэрэг үйлдэх үедээ эрхэлж байсан албан тушаалын эрх мэдэл болон үйл ажиллагаа явуулах

мэргэжлээ ашигласан буюу түүний үйлдсэн гэмт хэргийн шинж байдлаас уг этгээдэд тодорхой албан тушаал эрхлэх, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг нь эдлүүлэх боломжгүй гэж шүүх үзвэл үндсэн болон нэмэгдэл ялын хувьд 1-5 жил хүртэл хугацаагаар оногдуулна” гэсэн санааг тусгасан байна.

1996 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн Тусгаар тогтносон улсуудын хамтын нөхөрлөлийн орны Эрүүгийн загвар хуулийн 46 дугаар зүйлд нийт 14 буюу нэлээд олон ялын төрлийг хуульчилж өгсний дотор “албан тушаал хаших, үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах”, “цэргийн, тусгай хүндэтгэлийн цол, хэргэм зэрэг, улсын шагналыг хасах” гэх зэрэг ялын төрлүүд багтжээ.

Манай улс дээрх хуулийн гол үзэл баримтлалыг иш үндэс болгож 2002 онд Эрүүгийн хуулиа шинээр боловсруулан баталсан учир эрх хасах ялын “тодорхой албан тушаал эрхлэх, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах” гэсэн үндсэн гол 2 хэлбэрийг сонгож, харин “цэргийн, тусгай хүндэтгэлийн цол, хэргэм зэрэг, улсын шагналыг хасах” гэх ялын төрлөөс татгалзсан юм.

Харин 2015 оны Эрүүгийн хуулийг боловсруулахдаа АНУ, ОХУ, ХБНГУ, БНХАУ, Франц, Япон улсын Эрүүгийн хууль болон Олон улсын эрдэмтэд хамтран гаргасан “Гэмт хэргийн загвар хууль”, хууль санаачлах эрх бүхий субъектийн боловсруулсан төслүүд, эрдэмтэн судлаач, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн өгсөн шүүмж, эрдэм шинжилгээний өгүүлэл, тодорхой санал, зөвлөмжийг ашигласан болохоо уг “Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх “Танилцуулга” -даа дурджээ. (ХЗЯ. Эрүүгийн хуулийн төсөл, 2015, хууд. 5)

2007 оны Дэлхийн Эрүүгийн загвар хуулийн Ерөнхий ангийн 12 дугаар бүлгийг “Ял шийтгэл” гэж нэрлээд нэмэгдэл ялд в/ эрх хасах, д/ үйл ажиллагаа, албан тушаал эрхлэхийг хориглох, е/ иргэний харьяаллаас хасах гэх мэт төрөлтэй байхаар заасан /үз. 40 дүгээр зүйл/ байна. (ДЭЗХ, 2013, хууд. 14)

Монгол Улсад анхлан “гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн дотор өөрийн эрхэлж буй албан тушаал, ажил мэргэжлээ буруугаар ашиглах, эсхүл албан тушаал эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хайнга хандсанаас нийгэмд үлэмж хохирол учруулах явдал цөөнгүй. Энэ явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор ямар нэгэн тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу ажил эрхлэхийг хориглох ялыг хуульд оруулсан” байна. (Дэндэв, 1975, хуудсд. 50-51)

Манай шүүхийн практикт энэ ял нь ихэвчлэн тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг хасахаас өөр хэлбэрээр хэрэглэж байгаагүй учир “эрх хасах, хязгаарлах ял” гэж нэрлэж, “... гэмт хэрэг үйлдсэн хүний нийтийн албанд сонгогдох, томилогдох, тодорхой төрлийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг бүрмөсөн хасах, эсхүл 5 жил хүртэл хугацаагаар хязгаарлах, эрх эзэмших эрхийг хүчингүй болгох, тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх” гэсэн агуулгаар 2013 ба 2014 онуудын **Гэмт хэргийн тухай** хуулийн /төслийн/ үзэл баримтлалаар боловсрогдож байв. (ХЗЯ. Гэмт хэргийн тухай хуулийн төсөл. ХЗЯ. Гэмт хэргийн тухай хуулийн төсөл., 2013, 2014, хуудсд. 18, 20)

Харин 2015 оны Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлалаар “ял үр нөлөөтэй байх зорилгыг хангах үүднээс үндсэн ял эдэлж дууссаны дараа эрх хасах арга хэмжээг хэрэгжих байдлаар, ... эрх хасах ялыг гэмт хэрэг үйлдсэн хүний төрийн болон нийтийн албанд ажиллах, тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл тодорхой эрхийг 1 - 8 жил хүртэл хугацаагаар хориглож, нэмэгдэл ялын шинжтэй хэрэглэх” гэж авч үзсэн болно. (ХЗЯ. Эрүүгийн хуулийн төсөл, 2015, хуудсд. 9-10)

Ажлын хэсэг. Суурь зарчмын хувьд ... ялын хатуу хайрцаглагдсан бодлогуудаа бид задаллаа. Сая баталсан шинэ Эрүүгийн хуулийн гол үзэл баримтлал нь ялын бодлогын шинэчлэл ... эрх хасах ялыг нэмэгдэл ялын хэлбэрээр авлигын хэргүүд дээр ихэвчлэн заасан. Жолооны эрх, улс төрийн албан тушаал хаших эрхийг хасдаг байсан бол багш, эмч, хуульч, нягтлан бодогчоос авхуулаад гэмт хэрэг үйлдсэн бол тодорхой мэргэжлийн эрхийг нь хасаад эхэлнэ. (<https://itom.mn/article/3097>., 2016)

Бодит амьдрал дээр эрх хасах ялын хэрэгжилт нь хангалттай бус, нэгдсэн сан, судалгаа байхгүй, жишээ нь: Улаанбаатар хотод эрхээ хасуулсан эмч хөдөө орон нутагт ажиллаж байх г.м.

Шигтгээ: 1986 оны Эрүүгийн хуулийн 216 дугаар зүйлд “... тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах тухай шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхгүй байх”-ыг бие даасан гэмт хэрэгт тооцож /энэ эрхээ хасуулсан этгээд болон ийм шүүхийн шийдвэрийг ажилд авах, ажлаас халах эрх бүхий албан тушаалтанд/ ял оногдуулж байсан юм.

Улс төрийн өнгө аясаар бол харин ч нэг гайхамшигтай сайн оноо өгч болох, тухайлбал: шүүхээр эрхийг нь хасуулж байгаад сайдаас нь чөлөөлөх, эргэж төрд орох эрхгүй мэтээр тайлбарлах зэрэг. (Ганболд, 2016, хууд. 112)

Яг энэ санаагаа улс төрд нөлөө бүхий байх үедээ хийж авдаг бөгөөд үүнийгээ эрх зүйн шинэчлэл, шинэ үзэл баримтлалаар халхавч хийж

гүйцэлдүүлдэг явдал /өрсөлдөгчөө намнах, зайлуулах арга болгож/ байгаа нь нууц биш болжээ.

Жишээ нь: 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Эрүүгийн хуулийн 5.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн буюу **эрх хасах** ялын “... **хүртэл хугацаагаар ... эрх хасах**” гэснийг “... нийтийн албанд ажиллах **эрхийг бүх насаар ... хасах**” гэж өөрчлөв.

Дээрх энэ мэт улс төрийн эрх мэдэл шүүх рүү гар дүрээд зогсохгүй эрүүгийн эрх зүйд нэвтрэн орж байгаа нь үзэл баримтлалын хувьд маш хортой бөгөөд шинжлэх ухааныг устгах арга юм.

Энэ байдал улам газар авах аваас эрүүгийн эрх зүй – эрүүгийн ял улс төрийн зэвсэг болж хувирч, эрх мэдэлд хүрсэн дурын нэгэн нян бактерийн шинжлэх ухаанч биш хувийн амбиц, харизм, буруу сэхэх зэрэг хандлагаас болж хүний эрхийг хааж боодог, нухчин дардаг, айлган сүрдүүлдэг, эрүүгийн хэргээр барьцаалж, ялаар наймаацдаг тогтолцоо бэхжиж, шударга бусын хонгил руу хөврөх гинжин цуваа үргэлжлэх нь дамжиггүй.

Тэгсэн атлаа камерын өмнө уран сайхан ярьж, “үйлийн үр хаяг андуурдаггүй” гэхчлэн үнэмшмээр гоёхон уянгын халил бүхий агуулгатай контент нэвтрүүлж, урд хожид байгаагүй бузар булай мэт бусдыг хэлж, үүрдийн олдсон албан тушаалын эзэн аятай бүхнийг буруутгаж байгаа дүр төрхөөс үүдэн гардаг үзэл баримтлал л хамгаас аюултай. Ийм хуурмаг байдлыг зөвөөр таньж, хар цагааныг ялгах нь ус агаар мэт чухал. Үнэн үзэл, итгэл үнэмшил л үүнийг ялна.

Шигтгээ. 1926 оны Шүүх цаазын бичгийн 5 дугаар зүйлийн 12-т “аливаа эрхийг бүрэн эсхүл заримыг хугацаагаар буюу эсхүл үүрд эвдэх гэж заасан байсныг 1929 оны Шүүх цаазын бичигт “зарим нэг эрхийг хугацаагаар эвдэх” болгон мөн хуулийн 18 дугаар зүйлд чухам ямар эрхийг эвдэж болохыг тодруулан заагаад эрх эвдэх /хасах/ ялын хугацааг 1-5 жил байхаар заасан нь хууль ёсыг чанд сахин бэхжүүлэх, хүний эрхийн халдашгүй байдлын хууль цаазын баталгааг боловсронгуй болгосон чухал ач холбогдолтой болсон байна. (Совд, Дурдсан бүтээл, 1973, хууд. 62)

Хувь хүний ядмагхан санаа нь над мэтийн ганц хүнийг дийлж чадах ч “хорвоо дэлхий уужим хийх ажил их” учир холыг санахгүй аваас ойрын зовлон ирэх тул үг, үйлдлээ хувь хүн хичээж, хар санаа биеэ отож хар толгойгоо шааж суухгүйн тулд бусдад хор хүргэлгүй явах, хотол олон айл саахалтаараа эв эеийг хичээн амгалан тайван байх, улс гүрэн нь хүчтэй, өндөр их суудал нь тогтвортой, өнө мөнх оршин мандах ёстойг мартах аваас

“хэзээ нэгэн цагт, хэн нэгэн аавын хүү өөрийн чинь эрхийг хасаж” болзошгүйг бодолцох учиртай.

Эрүүгийн эрх зүйн сонгодог бүтээлд тооцогддог “Гэмт хэрэг ба ял” хэмээх 1764 оны бүтээлд дурдсанаар, “... албан тушаалтан байснаар ашиг хүртэж болох ч энэ нь түүнийг гэмээс хэлтрүүлэх учиргүй ... Өөрийгөө бусдын дээрээс харах тэрхүү боломжийг олгосон нийгмийн гэрээг зөрчвөл бусадтай адил цээрлэл амсах болно гэдгээ л мэддэг байх ёстой” ажээ. (Нарангэрэл, Дурдсан бүтээл, 2001, хуудсд. 201-202)

Шигтгээ. Эрүүгийн гэмт хэрэгтнүүд “хуулиар хориглоогүй бүхнийг зөвшөөрнө” гэсэн зарчмыг овжин ашиглаж, эрүүгийн бүтцүүд хууль тогтоогчдоос ялгаатай нь ирээдүйг илүү сайн урьдчилан харах боллоо. (Нарангэрэл, Дурдсан бүтээл, 2001, хуудсд. 201-202) Сүүдрийн эдийн засгийн хажуугаар сүүдрийн улс төр, дарамт шахалт үзүүлэх далд бүлэглэл гарч ирж, санаа муутай, булай явдалтнууд хуулиас огтхон ч үл айн, чадварлагаар бултан өнгөрөхдөө эрх зүйн янз бүрийн “цоорхой”, “сиймхий” зэргийг ашиглаж, бүрэн, хагас ил байдлаар /өөрийн шүүхтэй, өөрсдийн гэмт журмыг баримтлан/ ажиллаж байна.

ДҮГНЭЛТ

Эцэст нь тэмдэглэхэд, Ромын эрх зүйн төрөлжсөн эмхэтгэл болох **Юстинианы** хуульд “... Эзэн хааны хүсэж байгаа бүхэн эрх зүй” гэж заасан лугаа адил “... хууль зүйн сайдын хүсэж байгаа бүхэн хууль” болно гэдэг нь ёстой л эрх мэдэл түүний батжих аргын талаарх Германы эрдэмтэн **Макс Веберын** сургаал ёсоор “... Харизм, Уламжлалын давамгайлал, Хууль ёсны байдлуудын” аль болохоос л хамаарах мэт.

Уг чанар нь Германы гүн ухаантан **Г.Гегелийн** үзэл санааны утгаар бол “хууль тогтоогчид гагцхүү эрх зүйн ухамсраар дамжуулж, түүний ач нөлөөгөөр өөрийн оршин буй ерэн үеийн хамгийн дээд оюун ухааныг удирдлага болгож, гол санааг нь барин авч, түүнийгээ хуульд тусгаж байх” ёстой гэлтэй.

Эх сурвалж

<https://itom.mn/article/3097>. (2016 оны 01 07).

Ганболд, Б. (2016). Эрүүгийн номлол /зураглалт толь/. Улаанбаатар.

ДЭЗХ. (2013). Дэлхийн Эрүүгийн загвар хууль ба орчин үе. Улаанбаатар.

Дэндэв, Т. (1975). БНМАУ-ын эрүүгийн эрх зүй дэх ял шийтгэлийн тухай. Улаанбаатар.

Монгол Улсын Дээд шүүх, №4 (Мэдээлэл 2025).

Нарангэрэл, С. (1996). Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /Ерөнхий анги/. Улаанбаатар.

Нарангэрэл, С. (2001). Дурдсан бүтээл. Улаанбаатар.

Совд, Г. (1973). Дурдсан бүтээл. Улаанбаатар.

Совд, Г. (1995). Монгол Улсын Эрүүгийн цааз /онолын загвар/. Монголын төр, эрх зүй /сэтгүүл/, №4.

ХЗЯ. Гэмт хэргийн тухай хуулийн төсөл. ХЗЯ. Гэмт хэргийн тухай хуулийн төсөл. (Мэдээлэл 2013, 2014).

ХЗЯ. Эрүүгийн хуулийн төсөл (Мэдээлэл 2015).

ХЗЯ. Эрүүгийн хуулийн төсөл (Мэдээлэл 2015).

Чимид, Б. (2006). Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс. Улаанбаатар.